ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2026 оны 02 дугаар сарын 05 өдөр

Дугаар 38/2026

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

Объектын нэр:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11 дүгээр хороллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг, төсөв
Объектын байршил:	Орхон аймаг, Баян-Өндөр сум
Хүчин чадал:	0.971 км
Захиалагч:	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Маяа рафлес групп" ХХК
Регистрийн дугаар:	6464548
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2030.05.21
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	-
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Орхон аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр баталсан Орхон аймаг, Баян-Өндөр сумын доторх авто зам, зогсоол, үерийн усны байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар, № 01/2025,
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар болон "Маяа рафлес групп" ХХК-ийн хооронд 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан "11 дүгээр хороллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажил"-ын зураг төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, № ЗТБ-61/25, Зураг төсөл боловсруулах гэрээний үнэ: 81 315 122 төгрөг,

Техникийн нөхцөл:

Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Шинэ холболт	"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№ 592/25 2025.12.19	1 жил
Техникийн нөнцөл олгох тухай	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Орхон аймгийн газар	№ 30/146	-

Зөвшилцсөн байгууллага:

Орхон аймгийн ерөнхий архитектор	Ц.Нэмэхбаяр
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Б.Ганзориг
Орхон аймгийн Газрын харилцаа,барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга	Г.Буянхүү
Орхон аймгийн замын цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа	Х.Одбаяр
Орхон аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа	Ш.Баасандорж
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын авто замын улсын хяналтын ахлах байцаагч	Ш.Сүнжидмаа
"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер	Б.Эрдэнэцогт

1826050110
ЗАХ ХУВЬ
26 02 05

“Эрдэнэт ДЦС” ТӨХК-ийн ДШС-ийн цехийн дарга	А.Анхбат
“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер	Ц.Ууганбаяр
“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын ерөнхий инженер	Ц.Зориг

Зураг төслийн бүрэлдэхүүн:

Зургийн бүрдэл:	Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Авто замын зураг	“Маяа рафлес групп” ХХК	С.Батсүх
Тайлбар бичиг		
Техникийн шаардлага		
Авто замын төсөв		Д.Энхтуяа
Геодезийн тайлан	“Лэнд тест” ХХК	-
Инженер-геологийн тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2026.01.08-ны өдөр магадлал хийсэн байна./	“Лэнд тест” ХХК Архив № 25/585	-
Гэрэлтүүлгийн зураг	“Хайтал мегават” ХХК	Ж.Амарсанаа
Гэрэлтүүлгийн төсөв		Б.Октябрь
Холбооны зураг	“И энд Си дизайн” ХХК	Ж.Өлзийбаяр
Холбооны төсөв		Г.Гантуяа

Ерөнхий дүгнэлт:

Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт:	**Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:** **Авто замын ангилал:** 2А зэрэглэлийн хөдөө орон нутгийн хуримтлуулагч зам, Зорчих хэсгийн өргөн 7.0м, L хэлбэрийн хашлаганы өргөн 2х0.5м, ногоон байгууламжийн өргөн 2х1.0м, явган хүний замын өргөн 2х2.0м, хөвөөний өргөн 2х0.5м байхаар төлөвлөсөн байна. **Авто замын хучилтын хийц:** Өнгө асфальтбетон хучилт 30 мм Суурь асфальтбетон хучилт 40 мм Буталсан чулуун суурь 200 мм Суурийн доод үе 200 мм Хөлдөлтөөс хамгаалах үе 300 мм **Явган хүний замын хучилтын хийц:** Асфальтбетон хучилт 50 мм Буталсан чулуун суурь 150 мм **Төмөрбетон хоолой:** 1 байршилд ∅1.0м хэмжээтэй төмөрбетон дугуй хоолой байхаар төлөвлөсөн байна. **Авто замын гэрэлтүүлэг:** Хоёр толгойтой гэрэлтүүлгийн шон 33ш, 120вт-ын гэрлийн толгой 33ш, 60вт-ын гэрлийн толгой 33ш, АВВБШВ 4*25кв.мм гэрэлтүүлгийн кабель 1019м байхаар төлөвлөсөн байна. **Холбооны сувагчлал:** PVC 110мм-н хоолойтой /2+0/ сувагчлал байгуулах 85м, ТБУХ-3 худаг 5ш суурилуулах, шилэн кабель FO-12 сувагчлал 270м, 70м хэсэгт Ф273мм-н ган хоолойгоор хамгаалах, 1ш худаг буулгахаар төлөвлөсөн байна.
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд: <u>Зурагт:</u> Авто замын зурагт /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн зурагт /2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дүгнэлт/ Холбооны зурагт /2026 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн дүгнэлт/

ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗАР ЗХ ХУВЬ

М.Хишиг

26 02 05

	Төсөвт: Авто замын төсөвт /2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн төсөвт /2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дүгнэлт/ Холбооны төсөвт /2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн дүгнэлт/ Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно.
Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм норматив баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд: -ЗЗБНбД 22-004 -2016 "Авто зам төсөллөх" -БНбД 30-01-04 "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" -БНбД 32-01-06 "Хот суурины гудамж, зам төлөвлөлт" -БНбД 32-02-12 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" -ЗЗБНбД 83-25-2023 "Авто замын барилгын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 83-28-2023 "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 83-26-2023 "Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм" -ЗЗБНбД 81-013-2019 "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" -АЗУАГН 2.01.01-2004 "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" -MNS 4596:2014 "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" -MNS 4759:2014 "Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага" -MNS 4597:2014 "Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" -БНбД 81-95-12*/2020 "Барилгын төсөв зохиох дүрэм" -БНбД 43-101-03 "Цахилгаан байгууламжийн дүрэм" -БНбД 43-101-03*/12 "Цахилгаан байгууламжийн дүрэм" -БД 30-102-11 "Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх" -БНбД 23-02-08 "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг" -MNS 6305:2012 "Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл" -MNS 4908:2022 "Мэдээлэл холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ"
Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт	Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Авто замын барилгын ажлын төсөв **2 752 011 840** төгрөг, Гэрэлтүүлгийн ажлын төсөв **178 917 495** төгрөг, Холбооны кабелийг шилжүүлэх, сувагчлал байгуулах ажлын төсөв **92 142 795** төгрөг, Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянав.

"Авто замын тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.

Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11 дүгээр хороллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг, төсвийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр авто замын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗАР
ЭХ ХУВЬ
М. Хишиг
26 02 05

Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11 дүгээр хорооллын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг, төсвийн баримт бичиг "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 17 хуудас)

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ — Д.ОЮУНБОЛД

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.БАЛТ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Э.ЭНХТӨГС

ТӨРИЙН ӨМЧИТ ҮНДЭСНИЙ ГАЗАР
ЭХ ХУВЬ
М.Оюунт
26 02 05

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Авто замын зураг төсөл, МРГ25/12, 70

2026 оны 01 сарын 13 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Орхон аймгийн Засаг дарга Б. Зоригтбаярын 2025 онд баталсан 01/2025 дугаартай "Орхон аймгийн Баян-Өндөр сум доторх авто зам, зогсоол, үерийн усны байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар"-тай. Дараах байгууллагуудтай зөвшилцсөн байна: 1. Орхон аймгийн Ерөнхий архитектор бөгөөд "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын захирал Ц. Нэмэхбаяр 2. Орхон аймгийн ГХБХБГ-ын дарга Г. Буянхүү 3. Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг 4. Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ш. Баасандорж 5. Аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа Х. Одбаяр 6. "ЭБЦТСүлжээ" ТӨХК-ийн Ерөнхий инженер Б. Эрдэнэцогт 7. "ЭДЦСтанц" ТӨХК-ийн ДШС-ий Цехийн дарга Л. Анхбат 8. "ЭУДТС" ОНӨХК-ийн Ерөнхий инженер Ц. Ууганбаяр 9. "МХС" ХХК-ий Орхон аймаг дахь Салбарын менежер Ц. Зориг
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	1. Инженер-геологийн судалгааг "Лэнд тест" ХХК хийж дүгнэлт гарган Улсын магадлалаар баталгаажсан байна. 2. Инженер-геодези, байр зүйн зураглал ажлыг "Лэнд тест" ХХК гүйцэтгэж, тайлан гаргасан байна.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Авто замын трассыг Орхон аймгийн хэсэгчилссэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сонгосон бөгөөд холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн гэж тайлбар бичигт бичсэн байна.
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар тайланд бичээгүй. Нэмж бичих шаардлагатай
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар тайланд бичээгүй. Нэмж бичих шаардлагатай

Д/д	Утга	Тайлбар
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	1. "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-аас 592/25 дугаартай Техникийн нөхцөл авсан байна. 2. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-иас 30/146 дугаартай Техникийн нөхцөл авсан байна. 3. Цахилгаан, гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл дээр "Хайтал Мегаватт" ХХК, холбооны кабель шугам шилжүүлэх ажлын зураг төсөл, төсөв дээр "И энд Си дизайн" ХХК оролцсон гэж тайланд бичсэн байна.
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	ХБИ-нд зориулсан хөтөч хавтан төлөвлөсөн байна.
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Хавсралт-2 үзэх
Дүгнэлт бичсэн: Эксперт № 11-01 /С.Батсүх/ ..... 2026 оны 01 сарын 13 өдөр		

MONGOLIA
ЗЗИ-22/013
CONSULTING ENGINEER
S.BATSUKH
Sakhiya
2022-2027

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

Авто замын зураг төсөл

2026 оны 01 сарын 13 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Тайлбар бичигт: төслийн талаарх мэдээлэл хомс байна. Тайланг тусад нь дэлгэрэнгүй бичих: 1. Тооцоот хурд, авто замын ангилал, төсөллөлтийн нормын үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар 2. Дагуу хөндлөн огтлол төсөллөлт 3. хучилтын тооцоо 4. Гарц, уулзвар 5. Гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбооны шугамын тухай 6. Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны талаар 7.	1. Авто замын ангилалаас хамааран, тооцоот хурд, төсөллөлтийн норм үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар тайлбар бичигт тусгав. 2. Дагуу хөндлөн огтлол төсөллөлтийн талаар тайлбар бичигт оруулав. 3. Хучилтын тооцооны дутуу мэдээлэлүүдийг тайлбар бичигт тусгав. 4. Гарц уулзварын зай хэмжээ болон мэдээлэлүүдийг тайлбар бичигт тусгав. 5. Гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбооны шугамын тухай мэдээлэлүүдийг тайлбар бичигт 6. тусгав. 7. Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны талаар тайлбар бичигт тусгав
2	Инженер-геологийн тайлан: тусад нь магадлалаар баталгаажсан боловч дараах зөрүүтэй мэдээллүүдийг засах 1. Зам-цаг уурын бүсчлэлийг 1А, 2А гэж 2 янзаар бичиж, цаг уур амьсгалын үзүүлэлтүүдийг хольж бичсэн байна. 2.	1. Зам-цаг уурын бүсчлэлийн алдааг засаж хүргүүлэв.
3	Трасс сонголт: трассыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сонгосон гэсэн боловч дараах зүйлсийг тодруулах шаардлагатай байна: 1. Тайлбар, ажлын зурагт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл байхгүй 2. Трасс нь гэр хорооллын зүүн талаар дээшээ өгссөн замыг гол зам, түүнээс зүүн тийш салсан туслах зам байдлаар төлөвлөсөн бол сүлжээний хувьд зөв харагдахаар байна. Үүнийг судлах 3. Гэр хорооллын зүүн талын зам дагаж ирсэн гадаргуугийн ус нь одоогийн үерийн сувагт ордог байсан бололтой. Шинэ замын трасс нь энэ урсгалыг тасалсан байна. Энэ гадаргуугийн ус нь доош зам дагаж урсан, доод хэсэгийн барилга байгууламжийг усанд автах нөхцөлийг бүрдүүлсэн мэт харагдаж байна. Үүнийг судалж , Захиалагч байгууллагатай зөвшилцөх 4.	1. Тухайн авто замын трассын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний батлагдсан нүүрийг ажлын даалгаврын ард хавсаргав 2. Захиалагч байгууллагатай зөвшилцөн, батлагдсан трассын дагуу төлөвлөв. 3. Гэр хорооллын зүүн талын зам дагаж ирсэн гадаргуугийн ус нь одоогийн үерийн сувагт ордогүй бөгөөд 2 мөрт бетон замын шуудуу даган замын уулзварт нийлэх хэсэгт Ф500 ган хоолойгоор гарч доош жалаг даган урсаж борооны ус зайлуулах байгууламжруу ордог. Тус Ф500 ган хоолойг буулган Ф1000 төмөрбетон хоолойгоор борооны ус зайлуулахаар зураг төсөлд тусгав.
4	Хучилтын тооцоо: 1. Тооцоонд шавранцар ул хөрсийг авч үзсэн нь зөв. Гэхдээ овойлттой хөрсөнд хүйтэн тэсвэрлэлтийн тооцоо зайлшгүй хийх ёстой. Тооцооны үр дүнг харахад хүйтэн тэсвэрлэлтийн шалгуур харагдахгүй байна. 2. Тооцоонд хөлдөлтийн гүнийг хэдэн метрээр тооцсон нь харагдахгүй байна. 3. Дугуй мөрний ховилын тооцооны үр дүнг оруулах	1. Хүйтэн тэсвэрлэлтийн тооцоо хийж шалгуур үзүүлэлтийг хангуулан тайлбар бичигт тусгав. 2. Алдаа зөрчлийг засаж хүргүүлэв. 3. Дугуй мөрний ховилын тооцоонд оруулан хүргүүлэв.

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
5	Хөндлөн огтлолын төрөл: 1. Замын 2 талаар дугуйн замтай эсэх. тодруулах 2. Тооцоонд элс-хайрган хөрс сонгосон байсан тул Буталсан чулуун суурийн доор суурийн доод үе буюу элс-хайрган суурь авах 3. Хөлдөлтөөс хамгаалах үеийг хүйтэн тэсвэрлэлтийн тооцооны үндсэн дээр авах 4. Дугуйн замын буталсан чулуун суурийн доор ямар төрлийн хөрс байгаа вэ. 5. Ухаж байгаа шатны хэмжээсүүдийг бичих 6. Өндөр далантай хэсэгт явган, дугуйтай зорчигч унахаас сэргийлсэн явган замын хайс нэмэх 7. Хөрс хуулалтын зузааныг үзүүлэх	1. Замын 2 талаарх дугуйн зам байсныг засаж хүргүүлэв. 2. Буталсан чулуун суурийн доор суурийн доод үе хийв. 3. Хөлдөлтөөс хамгаалах үеийг хүйтэн тэсвэрлэлтийн тооцооны үндсэн дээр авав 4. Элс хайрган суурь 5. Ухаж байгаа шатны хэмжээсүүдийг бичин засав 6. Өндөр далантай хэсэгт, унахаас сэргийлсэн явган замын хайс тусгав. 7. Хөрс хуулалтын зузааныг үзүүлэв
6	Ажлын тоо хэмжээ: 1. Хатуу материалын ухмалын тоо хэмжээг нэмэх 2. Явган замын хайс нэмэх 3. Шаталж ухсаны дараа буцааж дүүргэх шороог тооцсон эсэхийг шалгах 4. Хөлдөлтөөс хамгаалах үе гэснийг суурийн доод үе болгох 5. Тооцоон дээр үндэслэн хөлдөлтөөс хамгаалах үеийг тооцох 6. Хоолойн бетоны ажил тус бүрийн арматурын орц, бетоны ангийг үзүүлэх	1. Ажлын тоо хэмжээнд хатуу материалын ухмалын тоо хэмжээ нэмэв 2. Өндөр далантай хэсэгт, унахаас сэргийлсэн явган замын хайс тусгав. 3. Буцаан дүүргэлтийн тоо хэмжээг тооцсон 4. Суурийн доод үе болгон тооцов 5. Тооцоон дээр үндэслэн хөлдөлтөөс хамгаалах үеийг тооцов 6. Хоолойн бетоны ажил тус бүрийн арматурын орц, бетоны ангийг зурагт засаж үзүүлэв
7	Дэвсгэр зурагт: 1. Трассын төгсгөл дээрх гурвалжин уулзварыг тодруулах. юутай нийлж байгаа, зүүн гарын эргэлтийн хөдөлгөөнийг хэрхэн хийх гм 2. Google earth сансрын зурган дээр төгсгөл орчимд хөндлөн гарсан явган зам байгаа бололтой. Үүнийг тодруулах. огтлолцсон хэсэгт явган гарц хийх. 3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, кадастрын мэдээллийг оруулж, шаардлагатай газар гарц төлөвлөх 4. Өнцгийн орой, хэвтээ эргэлтийн мэдээллүүдийг дэвсгэр зураг дээр үзүүлэх 5. Туузан хашилт хаана хийж байгаа вэ. байршлыг үзүүлэх	1. Урд төлөвлөгдсөн авто замын трасстай нийлж байгааг дэвсгэр зурагт харуулав, зүүн гарын хөдөлгөөнийг хэрхэн хийхийх хөдөлгөөн зохион байгуулалтын хэсэгт харуулав 2. Авто замын ПК9+30 таарч буй одоо байгаа явган зам дагуу явган гарц зураг төсөлд тусгагдсан. 3. Захиалагч байгууллагатай зөвшилцөн, батлагдсан трассын дагуух мэдээллийг ханган төлөвлөв 4. Өнцгийн орой, хэвтээ эргэлтийн мэдээллүүдийг дэвсгэр зураг дээр үзүүлэв 5. Дэвсгэр зурагт байршлыг үзүүлэв.
8	Хоолойн зурагт: 1. Хоолойн хийц, бүтээц тус бүрд бетоны ангийг /В/ бичих 2. Хоолойн цагирагны бетон В30 болгох. зурагнууд дээр байгаа шахалтын бат бэх болон бетоны ангиуд хоорондоо таарахгүй байгааг засах 3. 1м-ийн хоолойн арматурын түүврийн зураг дээр хүснэгт давхардсаныг хасах	1. Бетоны ангийг /В/ бичин засаж хүргүүлэв 2. Шахалтын бат бэх болон бетоны ангиуд хоорондоо таарахгүй байгааг засаж хүргүүлэв 3. Давхардсаныг хасав
9	Дагуу огтлолд: 1. Дагуу огтлолыг 1:200, 1:2000 масштабтай хийх 2. Хөрсний зүсэлтийг харуулах 3. Төгсгөлийн гурвалжин уулзвартай хэсгийн дагуу налуу аль болох 4%-иас хэтрүүлэхгүй авах 4. пк4, 5, 6 дээрх хуваалтууд зөрөөд байгаа нь ямар учиртай вэ.	1. Дагуу огтлолыг 1:200, 1:2000 масштабтай хийв 2. Дагуу огтлолд хөрсний зүсэлтийг харуулав 3. Дагуу налуу 4%-иас хэтрүүлэхгүй тооцов 4. Масштаб таарахгүй хуудаслалтын алдаанаас
10	Хөндлөн огтлолд: 1. Дэвсгэрний налуу эсрэг зурагдсаныг засах 2. Дэвсгэрийн өргөнийг 2м болгох 3. пк0+00 дээрх хөндлөн буруу зурагдсаныг засах 4. Дагуу огтлол болон хөндлөн огтлолын хар өндөр зөрүүтэй байгааг засах 5. Хөндлөн огтлол дээр ажлын өндөр, тоо хэмжээний талбай зэргийг харуулах 6. Шаталж ухаж байгаа нь зөв боловч, өргөнийг 3м-ээс хэтрэхгүйгээр хязгаарлах	1. Дэвсэгний налуу эсрэг зурагдсаныг засав 2. Дэвсэгийн өргөнийг ухмалтай хэсэгт 2м-ээр тооцон засав 3. пк0+00 дээрх хөндлөн буруу зурагдсаныг засав 4. Дагуу огтлол болон хөндлөн огтлолын хар өндөр зөрүүтэй байгааг засав 5. Хөндлөн огтлол дээр ажлын өндөр, тоо хэмжээний талбай зэргийг харуулав 6. Өргөнийг 3м-ээс хэтрэхгүйгээр хязгаарлав
11	Бусад: 1. Хөндлөн огтлолоос харахад шуудууг бэхэлсэн бололтой. шуудууны бэхэлгээ, байрлалыг харуулсан зураг нэмэх 2.	1. Шуудууны бэхэлгээ, байрлалыг харуулсан зураг нэмэв

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
12	Замын тоноглол: 1. Гэрэлтүүлэг төлөвлөсөн бол дэвсгэр зураг дээр байрлалыг харуулах 2. Гарцны орчимд зам салах, эсвэл гол зам тэмдэг тавих 3. Дохионы шонгийн зураг, байрлалыг үзүүлэх	1. Гэрэлтүүлгийн дэвсгэр зургийг, дэвсгэр зураг дээр байрлуулан харуулав 2. Гарцны орчимд зам салах тэмдэг тавив 3. Дохионы шонгийн зураг, байрлалыг үзүүлэв
13	Техникийн шаардлага: 1. Ирүүлсэн ТШ нь хуучин ТШ бна. Үүнийг ЗТХТ-өөс гаргасан жишиг ТШ-ыг үндэслэл болгон бичих 2. Бүх бүлэг, заалтуудыг ажлын зурагтайгаа уялдуулах 3. Бетоны маркыг Бетоны ангиар /В/ үзүүлэх 4. Шингэн битумыг хасч, битумын эмульс цацахаар оруулах	1. ЗТХТ-өөс гаргасан жишиг ТШ-ыг үндэслэл болгон тусгав 2. Бүх бүлэг, заалтуудыг ажлын зурагтайгаа уялдуулав 3. Бетоны маркыг Бетоны ангиар /В/ үзүүлэв 4. Шингэн битумыг хасч, битумын эмульс цацахаар оруулан тооцов

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 11-01 ..... /С.Батсүх/

2026 он 01 сар 13 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн .....Т.Батсүрэн..... /Т.Батсүрэн/

2026 он 01 сар 25 өдөр

MONGOLIA ЗЗИ-22/013 CONSULTING ENGINEER BATSUKH Association 2022-2027

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

1. ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:

ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ, 11-Р ХОРООЛЛЫН Б ХЭСГИЙН АВТО ЗАМЫГ БАЯНБУЛАГ БАГИЙН АВТО ЗАМТАЙ ХОЛБОХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ

д/д	Утга	Тайлбар
1	Объектийн байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Объектийн нэр, шифр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох авто замын барилгын ажлын төсөв Замын урт-0,971 км Зургийн шифр: МРГ25/12 Төсвийн шифр: 26*01
3	Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгуулага	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох авто замын барилгын ажлын төсөв Замын урт-0,971 км Зургийн шифр: МРГ25/12 Төсвийн шифр: 26*01 Захиалагч байгууллага: “Орхон аймгийн Засаг даргын тамгын газар” Зураг төслийн байгууллага: “Маяа рафлес групп” ХХК
4	Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНбД 81-013-2019, 4 дүгээр хавсралтаар баталсан “Автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн.км-ийн жишиг тариф”, Ажилчдын тарифт цалинг Зам, Тээврийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”, 2 дугаар хавсралтаар баталсан “Авто зам, замын байгууламжийн машин ашиглалтын нэг машин цагийн үнэ”-ийг ашиглан төсөв бодох компьютерийн “Road-Estimator” программ ашиглан төсвийн тооцоог хийсэн байна. Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох авто замын барилгын ажлын төсвийг “Маяа рафлес групп” ХХК, Мэргэшсэн төсөвчин Г.Батсүрэн хийж гүйцэтгэсэн байна.

5	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг төсвийн тооцоонд хавсаргасан байна. Баталгаажуулалт хийх, Зөвлөх, Зургийн инженер нар гарын үсэг зурах шаардлагатай.
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	Төсвийн тооцоог ЗЗБНбД 83-25-2023, ЗЗБНбД 83-26-2023, ЗЗБНбД 83-28-2023 суурь жишиг нормîîр үнэлсэн байна.
7	Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	Төсвийн тооцооны иж бүрдэл хангагдсан байна.
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт	Төсвийн тооцоонд хавсаргах шаардлагатай материалууд: Үүнд: 1. "Түр барилга үйлдвэрлэлийн бэлтгэл ажил" бүлэгт орсон ажилд "Зохист найрлага бүхий элс хайрган хольц"-ыг 1 төгрөгөөр материалын үнэ тооцсон байна. Үүнийг Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх. 2. "Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил" бүлэгт "Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах" ажилд Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох. 3. "Замын далан, ухмалын ажил" бүлэгт "Зөөврөөр далан байгуулах" ажилд бульдозерыг 245 м.х-ээр, Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох. 4. Далангийн материалыг төсөвт 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тйлбар ирүүлэх. 5. "Замын суурийн ажил" бүлэгт "Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах" ажилд бульдозерыг 245 м.х-ээр тооцох, 6. Далангийн материалыг төсөвт 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх. 7. ХХҮ-ийн материалыг 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх. 8. "Буталсан чулуун хольцоор суурь байгуулах (автогрейдерээр)" ажлыг дэвсэгчээр тараахаар оруулах эсэхийг Зуургийн инженерээс тодруулах, Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох. 9. "Замын хучилтын ажил" бүлэгт "Халуун асфальтбетон хольцоор өнгө үе байгуулах" ажилд "Жижиг ширхэглэлтэй халуун асфальтбетон хольц" 1тн-г 252000 төгрөгөөр тооцсон үндэслэл, тайлбарыг ирүүлэх, маш өндөр үнээр тооцсон байна, төсөвт өртөгт шууд нөлөөлж байна. Иймд яагаад асфальтбетон хольцны үнэ 1тн=252000 төгрөг байгааг үндэслэлтэй калькуляци ирүүлэх нь зүйтэй гж үзэж байна. 10. Асфальтбетон хучилтын өргөн хэдэн м байна, сонгосон дэвсэгчийн өргөн хангагдах эсэхийг тодруулах. 11. "Халуун асфальтбетон хольцоор суурь үе байгуулах ажилд "Дунд ширхэглэлтэй халуун

		асфальтбетон хольц"-ны үнийг дээрхтэй адилхан үндэслэл, тайлбар ирүүлэх. 12. "Замын хайрган хөвөө байгуулах" бүлэгт Хайрган хөвөөг механизмаар байгуулахаар яагаад тооцоогүй, гараар тооцох нь зөв эсэх талаар Зургийн инженерээс тодруулж, тооцох. 13. "Замын ус зайлуулах энгийн байгууламжийн ажил" бүлэгт "Шуудуутай хэсгийн орц гарцанд ган хоолой байрлуулах" ажилд орсон "ус зайлуулах ган хоолой"-ны үнийг ямар үндлэслэлээр тооцсон бэ? 31 м хоолой 8,0 сая төгрөгөөр тусгасан байна, хир үндэслэлтэй вэ? Тайлбарлах, үндэслэл гаргах. 14. "Төмөрбетон дугуй хоолойн барилга - d1000" бүлэгт "Хоолойн ул суурь нягтруулах" ажилд Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох. 15. "Хоолойн суурийг зохистой ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах" Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох. 16. "Төмөрбетон суурь байгуулах, d1000" ажилд арматурын үнийг 1 тн=2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох. 17. "Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах, d1000" ажилд арматурын үнийг 1 тн = 2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох 18. "Төмөрбетон тулц цутгах" ажилд арматурын үнийг 1 тн=2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох 19. "Цементбетон тулц цутгах", "Төмөрбетон тулц цутгах" ажил 2 лаа байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах. 20. "Хоолойн орох, гарах хэсгийн чулуун бэхэлгээ хийх" ажилд Экскаватор гидро-молоток механизм байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах, хасах саналтай байна. 21. "Далангийн хажуу налуугийн элс цементэн зуурмагтай чулуун бэхэлгээ хийх" ажилд Экскаватор гидро-молоток механизм байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах, хасах саналтай байна. 22. "Тээврийн зардалд" Далангийн материал, хөвөөний материал, хөлдөлтөөс хамгаалах үеийн материал, буталсан чулуу, зохист найрлагатай хольц материалыг 15 км-т тээвэрлэхээр төсөвт тусгасан байна, тээврийн зайг тооцсон үндэслэлийг гаргаж, танилцуулах. 23. Тохиромжгүй материалын тээврийн зайг тодруулах, үндэслэлийг тайлбарлах. 24. Хаягдал материал тээвэрлэх зайг тодруулах, тайлбарлах.
	Дүгнэлтийн товч утга	
1	Төсвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм,	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай

	стандартын дагуу оновчтой зохиогдсон эсэх	холбох авто замын барилгын ажлын төсвийн тооцоог хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн суурь норм, төсөв бодох нормын дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Магадлалын дүгнэлтээр тодорхойлсон алдаа дутагдлыг засаж дахин хянуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Дүгнэлт бичсэн:

Эксперт №12-01 Д.ЭНХТУЯА

МОНГОЛ УЛС Д.ЭНХТУЯА ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН ЗТТ-029-95

2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

ЭКСПЕРТИЗИЙН ДҮГНЭЛТИЙН ХАРИУ

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл

2026 оны 01 сарын 29-ний өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Объектын байршил, хүчин чадал:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хорооллын б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох авто замын барилгын ажлын төсөв Замын урт-0,971 км Зургийн шифр: МРГ25/12 Төсвийн шифр: 26*01
3	Зураг төслийн байгууллага:	"МАЯА РАФЛЕС ГРУПП " ХХК
д/д	*Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил*	*Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга*
1	"Түр барилга үйлдвэрлэлийн бэлтгэл ажил" бүлэгт орсон ажилд "Зохист найрлага бүхий элс хайрган хольц"-ыг 1 төгрөгөөр материалын үнэ тооцсон байна. Үүнийг Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх.	Зохист найрлага бүхий элс хайрган хольцын үнийг 1500 төгрөгөөр төсөвт тусгав.
2	"Замын трасс, талбайн цэвэрлэгээний ажил" бүлэгт "Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах" ажилд Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох.	Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцовн засав
3	"Замын далан, ухмалын ажил" бүлэгт "Зөөврөөр далан байгуулах" ажилд бульдозерыг 245 м.х-ээр, Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох.	"Замын далан, ухмалын ажил" бүлэгт "Зөөврөөр далан байгуулах" ажилд бульдозерыг 245 м.х-ээр, Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцон засав.
4	Далангийн материалыг төсөвт 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх.	Карьераас тээвэрлэх материалын үнийг 1500 төгрөгөөр тооцон төсөвт тусгав
5	"Замын суурийн ажил" бүлэгт "Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах" ажилд бульдозерыг 245 м.х-ээр тооцох,	Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах ажилд бульдозерыг 245 м.х-ээр тооцов
6	Далангийн материалыг төсөвт 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх.	Карьераас тээвэрлэх материалын үнийг 1500 төгрөгөөр тооцон төсөвт тусгав
7	ХХҮ-ийн материалыг 1 төгрөгөөр тооцож оруулах эсэх талаар Захиалагчаас тодруулах, тайлбар ирүүлэх.	Карьераас тээвэрлэх материалын үнийг 1500 төгрөгөөр тооцон төсөвт тусгав
8	"Буталсан чулуун хольцоор суурь байгуулах (автогрейдерээр)" ажлыг дэвсэгчээр тараахаар оруулах эсэхийг Зуургийн инженерээс тодруулах, Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох.	Буталсан чулуун хольцоор суурь байгуулах үеийг дэвсэгчээр тараахаар тооцон засав.

9	"Замын хучилтын ажил" бүлэгт "Халуун асфальтбетон хольцоор өнгө үе байгуулах" ажилд "Жижиг ширхэглэлтэй халуун асфальтбетон хольц" 1тн-г 252000 төгрөгөөр тооцсон үндэслэл, тайлбарыг ирүүлэх, маш өндөр үнээр тооцсон байна, төсөвт өртөгт шууд нөлөөлж байна. Иймд яагаад асфальтбетон хольцны үнэ 1тн=252000 төгрөг байгааг үндэслэлтэй калькуляци ирүүлэх нь зүйтэй гж үзэж байна.	Жижиг ширхэглэлтэй халуун асфальтбетон хольцын үнийг экспертын зөвшөөрч буй 1тн=225000 төгрөг байхаар төсөвт тусгав.
10	Асфальтбетон хучилтын өргөн хэдэн м байна, сонгосон дэвсэгчийн өргөн хангагдах эсэхийг тодруулах.	Авто замын зорчих өргөн 7м тул дэвсэгчийн өргөн хангагдаж байна.
11	"Халуун асфальтбетон хольцоор суурь үе байгуулах ажилд "Дунд ширхэглэлтэй халуун асфальтбетон хольц"-ны үнийг дээрхтэй адилхан үндэслэл, тайлбар ирүүлэх.	Дунд ширхэглэлтэй халуун асфальтбетон хольцын үнийг экспертын зөвшөөрч буй 1тн=220000 төгрөг байхаар төсөвт тусгав.
12	"Замын хайрган хөвөө байгуулах" бүлэгт Хайрган хөвөөг механизмаар байгуулахаар яагаад тооцоогүй, гараар тооцох нь зөв эсэх талаар Зургийн инженерээс тодруулж, тооцох.	Зургийн инженерээс тодруулан, хайрган хөвөөг механизмаар байгуулахаар засав
13	"Замын ус зайлуулах энгийн байгууламжийн ажил" бүлэгт "Шуудуутай хэсгийн орц гарцанд ган хоолой байрлуулах" ажилд орсон "ус зайлуулах ган хоолой"-ны үнийг ямар үндлэслэлээр тооцсон бэ? 31 м хоолой 8,0 сая төгрөгөөр тусгасан байна, хир үндэслэлтэй вэ? Тайлбарлах, үндэслэл гаргах.	Ган хоолойн үнийг зах зээлийн үнээр засаж тооцон хүргүүлэв
14	"Төмөрбетон дугуй хоолойн барилга - d1000" бүлэгт "Хоолойн ул суурь нягтруулах" ажилд Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох.	Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцовн засав.
15	"Хоолойн суурийг зохистой ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах" Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцох.	Доргиурт индүүг-17-20 тн-оор тооцовн засав.
16	"Төмөрбетон суурь байгуулах, d1000" ажилд арматурын үнийг 1 тн=2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох.	Арматурын үнийг зах зээлийн үнээр засаж тооцон хүргүүлэв
17	"Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах, d1000" ажилд арматурын үнийг 1 тн = 2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох	Арматурын үнийг зах зээлийн үнээр засаж тооцон хүргүүлэв
18	"Төмөрбетон тулц цутгах" ажилд арматурын үнийг 1 тн=2500000 төгрөгөөр тооцсон байна. Үндэслэлийг тайлбарлах, одоогийн зах зээлийн ханшийг судлаж, төсөвт тооцох	Арматурын үнийг зах зээлийн үнээр засаж тооцон хүргүүлэв
19	"Цементбетон тулц цутгах", "Төмөрбетон тулц цутгах" ажил 2 лаа байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах.	Давхардсаныг засаж хүргүүлэв
20	"Хоолойн орох, гарах хэсгийн чулуун бэхэлгээ хийх" ажилд Экскаватор гидро-молоток механизм байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах, хасах саналтай байна.	Зургийн инженерээс тодруулан Экскаватор гидро-молоток механизмыг хасаж тооцон засав

21	“Далангийн хажуу налуугийн элс цементэн зуурмагтай чулуун бэхэлгээ хийх” ажилд Экскаватор гидро-молоток механизм байх эсэхийг Зургийн инженерээс тодруулах, хасах саналтай байна.	Зургийн инженерээс тодруулан Экскаватор гидро-молоток механизмыг хасаж тооцон засав
22	“Тээврийн зардалд” Далангийн материал, хөвөөний материал, хөлдөлтөөс хамгаалах үеийн материал, буталсан чулуу, зохист найрлагатай хольц материалыг 15 км-т тээвэрлэхээр төсөвт тусгасан байна, тээврийн зайг тооцсон үндэслэлийг гаргаж, танилцуулах.	Хамгийн ойр карьер болох Эрдэнэт булганы зам дагуух 10км карьераас тээвэрлэхээр зайг засаж хүргүүлэв.
23	Тохиромжгүй материалын тээврийн зайг тодруулах, үндэслэлийг тайлбарлах.	Тус авто зам нь Орхон аймгийн хотын төвд хийгдэж байгаа тул тохиромжгүй материалын буулгах зайг сууршлын бүсээс 4км зайд буулгахаар тусгав.
24	Хаягдал материал тээвэрлэх зайг тодруулах, тайлбарлах.	Тус авто зам нь Орхон аймгийн хотын төвд хийгдэж байгаа тул хаягдал материалын буулгах зайг хогын цэг дээр буулгахаар тооцон хийв

Дүгнэлт бичиж,биелэлтийг шалгасан эксперт № ..... /Д.Энхтуяа/

2026 оны 01-р сарын 29-ний өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн Мэргэшсэн төсөвчин . . . . . /Т.Батсүрэн/

2026 оны 01-р сарын 29-ний өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төсөл

2026 оны 01 сарын 13 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
3	Зураг төслийн байгууллага	"Хайтал мегават" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	ЭБЦТС ТӨХК-н 2025-12-19 өдрийн №592/25 тоот техникийн нөхцлийн дагуу хийж гүйцэтгэсэн. " ЭБЦТС" ТӨХК-н Ерөнхий инженер Б.Эрдэнэцогт баталгаажуулсан байна.
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	" ЭБЦТС " ТӨХК-н 2025-12-19 өдрийн №592/25 тоот техникийн нөхцлийн дагуу хийж гүйцэтгэсэн .БД43-101-03 Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Норм дүрмийн дагуу төлөвлөсөн.
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Угсралтын үед хөдөлмөр аюулгүй ажиллагааг мөрдлөг болгох.
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Норм дүрмийн дагуу төлөвлөсөн.
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Угсралтын үед ААД, ТАД, ЦБД-н дагуу гүйцэтгэх.
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Техникийн нөхцлөөр КТПН-654 дэд өртөөний 0,4кВ талд автомат бүхий групп тоноглож дэд өртөөний хажууд бетон суурьтай иж бүрэн тоноглогдсон гэрэлтүүлгийн удирдлагын самбар төлөвлөсөн.
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	Холбогдох норм дүрмийг баримтлах
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Уг зураг төслөөр угсралтын ажлыг гүйцэтгэх боломжтой гэж үзэв.
Дүгнэлт бичсэн: Эксперт № 61-01 /Ж.Амарсанаа/ ..... 2026 оны 01 сарын 13 өдөр		

MONGOLIA CONSULTING ENGINEER AMARSANAA Jamtsaa 02-325

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

Гэрээний дугаар-

ЗУРАГ ТӨСЛИЙН ХЭСГИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР: **ТӨСВИЙН ТООЦОО**

2026.02.05

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын байршил , хүчин чадал	Орхон аймаг Баян-Өндөр сум Баянбулаг багийн уулзвар болон 11-р хорооллын авто замын сүлжээтэй холбох 1 км авто замын гэрэлтүүлэгийн ажил / гэрэлтүүлэг 2х33ком/
2	Объектын нэр	Орхон аймаг Баян-Өндөр сум Баянбулаг багийн уулзвар болон 11-р хорооллын авто замын сүлжээтэй холбох 1 км авто замын гэрэлтүүлэгийн ажил
3	Объектын бүрдэл хэсгийн нэр, марк, хуудасны тоо гүйцэтгэсэн ААН, байгууллага ,инженер	"Хайтал Мегават" ХХК-ийн гүйцэтгэсэн гэрэлтүүлэгийн ажил ХМ-2025/92 шифр бүхий зураг Захирал: Б.Гантөгс Гүйцэтгэсэн: Э.Амин-Эрдэнэ Шалгасан: Б.Гантөгс
4	Тооцоо, тооцооны программ,тооцсон байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Төсвийн "Эстиматор Про" программаар төсөв зохиосон мэргэшсэн төсөвчин А.Энхцэцэг
5	7.6 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж норм нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт техникийн үндсэн шийдэл эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч техник эдийн засгийн үндэслэлд нэмж тусгах буюу хасах өөрчлөх асуудлын талаар товч тодорхой тусгана.	Орхон аймаг Баян-Өндөр сум Баянбулаг багийн уулзвар болон 11-р хорооллын авто замын сүлжээтэй холбох 1 км авто замын гэрэлтүүлэгийн ажлын төсөвт өртөгийг **178,917,495** төгрөгөөр хянав**.** Төсвийг "Хайтал Мегават" ХХК гүйцэтгэж магадлал хийгдсэн ажлын зургийн дагуу **мэргэшсэн төсөвчин А.Энхцэцэг** "ЭстиматорПро" программаар тооцсон ЗТХ-ийн сайдын 2019/256, машин механизмыг ЗТБХБ-ын сайдын 2012/18, цалинг 2024/95, ашиг нэмэгдэл зардал, зохиогчийн хяналтын зардлыг БХБ-ын сайдын БХБ-ын сайдын 2020/30 тоотуудын дагуу тооцсон байна. Материалын үнийг хүчин чадлын үзүүлэлт, зах зээлийн үнэд үндэслэсэн байна.
Дүгнэлт бичсэн: Эксперт № 62-03 ...../ Б.Октябрь /		

МОНГОЛ УЛС Барилгын ОКТЯБРЬ ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН Т-ЭХББ 13-225 ГСТ7750

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Холбооны зураг төсөл, 6

2026 оны 01 сарын 21 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Орхон аймгийн газрын 2025 оны 11-р сарын -ны өдрийн 30/146 дугаартай техникийн нөхцлийг үндэслэн И энд Си дизайн ХХК-ийн инженер Э.Мядагбадам, Б.Одбаяр нар ЕС-25-А3-072 шифртэй ГХ1-ГХ6 хуудастай ажлын зургийг боловсруулсан байна. Трассын тойм зурагт Орхон аймгийн МХС ХХК-ийн газар, ЭБЦТС ТӨХК, ЭУДТС ТӨХК, ЭБЦТС ТӨХК зэргээс зөвшөөрөл авсан байна.
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Гадна холбооны ажлын зургийг барилгын болон холбоо мэдээллийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм, стандартын дагуу боловсруулсан байна.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Автозам хөндлөн гарч буй хэсэгт сувагчлалыг стандартын дагуу ган хоолойгоор, давхар 30мм PVC хоолойгоор хамгаалан шилжүүлэхээр төлөвлөсөн байна.
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Орчны тойм зургийг хийж, Баянбулаг багийн зам хаана байгааг тодруулах, Материалын түүвэрт тэмдэгийн шон 4ш байхыг хянаж засах
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Автозамын трасст таарсан МХС ХХК-ийн эзэмшлийн холбооны 2ш газрын шилэн кабелиудыг шилжүүлэн хамгаалах ажилд 85м /2+0/ сувагчлал байгуулан 273мм ган хоолойг 70м автозам хөндлөн газарт төлөвлөсөн байна. Шинээр суурилуулсан худагтай холбохын тулд одоо байгаа шилэн кабелийг 103м газарт ухаж гарган 32мм холойгоор хамгаалахаар төлөвлөсөн байна.
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Дээр заасан засваруудыг хийсэн гүйцэтгэлээр уг ажлын зургийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэх боломжтой.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 71-02 /Ж.Өлзийбаяр/ .....

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР № 08-096 ЖАНЦАНБАГАНЫ ӨЛЗИЙБАЯР Ulziibayar Janchanbaganyn 11184565 10 MONGOLIAN CONSULTING ENGINEER

2026 оны 01 сарын 21 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

Холбооны зураг төсөл

2026 оны 01 сарын 21 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Орчны тойм зургийг хийж, Баянбулаг багийн зам хаана байгааг тодруулах, Материалын түүвэрт тэмдэгийн шон 4ш байхыг хянаж засах	Засварт хийсэн

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 71-02 ..... /Ж.Өлзийбаяр/

2026 он 01 сар 21 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /овог, нэр/

..... он ..... сар ..... өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /Төсвийн тооцоо/

Д/д	Утга	Тайлбар
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/хороо; 1 км
2	Обьектын нэр, шифр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, 11-р хороололын Б хэсгийн авто замыг Баянбулаг багийн авто замтай холбох ажлын зураг төсөл, МРГ25/12
3	Обьектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	Холбооны төсөв, "Маяа рафлес групп" ХХК
4	Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Estimator-pro-4 программ. Тэргүүлэх төсөвчин Ж.Өлзийбаяр Магадлалд ирүүлсэн төсөв: 92,142,795 төгрөг
5	Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	Ажлын тоо хэмжээг зөв тооцсон.
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	Төсвийн тооцоонд БНбД 81 төсвийн суурь нормууд, БХБС-ын 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн 30 тоот тушаалаар батлагдсан Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12*/2020, Цалингийн зардалд БХБС-ын 2024 оны 95-р тушаал, тээврийн зардалд ЗТХС-ын 2019.12.13-ны өдрийн 256-р тушаал, механизмын зардалд ХББОСС-ын 2025.06.06-ны 138-р тушаалыг ашиглажээ.
7	Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт	Өөрчлөлтгүй
	Дүгнэлтийн товч утга	
1	Төвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу, оновчто зохиогдсон эсэх	Төсвийн тооцоо нь норм, дүрэм стандартын дагуу тооцогдсон тул 92,142,795 төгрөгөөр баталгаажуулав.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 72-01 /Г.Гантуяа/ .....

2026 оны 01 сарын 22-ны өдөр